



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 4 дэх хэсэг 4.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. “Гишүүнчлэлийн журам”-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад дурдсан нэр бүхий 7 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Өлзийбат/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

“МХБ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн
...~~А/12~~... дугаар тушаалын хавсралт



**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр
хязгаарлах арга хэмжээ авагдах гишүүн үнэт цаасны
компаниуд**

1. "Азиа пасифик секьюритис ҮЦК" ХХК
2. "Алтан хоромсог ҮЦК" ХХК
3. "Гацуурт трейд ҮЦК" ХХК
4. "Дэлгэрхангай секьюритиз ҮЦК" ХХК
5. "Евразиа капитал холдинг ҮЦК" ХК
6. "Капитал маркет корпораци ҮЦК" ХХК
7. "Лайфтайм инвестмент ҮЦК" ХХК

---oOo---